

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 07.100.30

Хүнсний микробиологи. <i>Listeria monocytogenes</i> ба <i>Listeria</i> spp. илрүүлэх, тоолох ерөнхий арга. 1-р хэсэг: Илрүүлэх арга	MNS ISO 11290-1:2020
Microbiology of the food chain — Horizontal method for the detection and enumeration of <i>Listeria monocytogenes</i> and of <i>Listeria</i> spp. —Part 1: Detection method	ISO 11290-1:2017-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

АНХААРУУЛГА—Лабораторийн ажилтны эрүүл мэндийг хамгаалахын тулд, *L.monocytogenes* ба *Listeria* spp. илрүүлэх шинжилгээг зөвхөн чадварлаг микробиологчийн хяналтанд, зохих ёсоор тоногдсон лабораторид явуулах ба өсгөвөрлөсөн бүх материалыг устгахдаа маш анхааралтай ажиллана. Энэ стандартыг хэрэглэж буй хүмүүс лабораторийн энгийн практик ажлыг мэддэг байх шаардлагатай. Энэ стандарт нь аюулгүй ажиллагааны бүх асуудлыг шийдвэрлэхгүй боловч түүнийг заасан тохиолдолд зааварчилгааг дагаж мөрдөнө. Аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих дадлыг тогтоох, үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөх зэрэг нь стандарт хэрэглэгчийн үүрэг юм. Ялангуяа *L. monocytogenes*-ийг илрүүлэх шинжилгээг биоаюулгүйн 2-р зэрэглэлийн лабораторид гүйцэтгэхийг зөвлөж байна. Мөн лабораторийн эмэгтэй ажилтан *L.monocytogenes*, *Listeria* spp.-ийн халдвар эхээр дамжин ургийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг эрсдлийн талаар мэддэг байх, жирэмсэн болон бие султай эсвэл ямар нэгэн дархлааны эмгэгтэй хүн *L. monocytogenes*, *Listeria* spp.-ийн өсгөвөртэй харьцаж болохгүй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь дараах ерөнхий аргыг заана

- *L.monocytogenes*-ийг илрүүлэх, мөн
- *Listeria* spp.-ийг илрүүлэх (үүнд *L.monocytogenes* багтана).

Энэхүү стандарт нь

- хүний хэрэгцээнд зориулагдсан болон малын тэжээлийн бүтээгдэхүүн
- хүнс үйлдвэрлэх болон түүнтэй харьцах орчны дээж зэргийг хамаарна.

Listeria-ийн зүйлүүд энэ аргаар илрүүлж, батлах боломжгүй байдаг тул нэмэлт арга хэрэглэхийг зөвшөөрдөг.^{[5],[10],[12],[14],[25],[26],[27]}

2 Норматив эшлэл

Энд зарим буюу бүх агуулга нь энэхүү стандартын шаардлагыг бүрдүүлдэг дараах баримт бичгийг заана. Хугацаа заасан ишлэлийн хувьд зөвхөн дурдсан хэвлэлийг хэрэглэнэ. Хугацаа заагаагүй эшлэлийн хувьд, эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (аливаа нэмэлт өөрчлөлтийг оруулаад)-ийг хэрэглэнэ.

ISO 6887 (бүх хэсгүүд), *Microbiology of food and animal feeding stuffs—Preparation of test samples, initial suspension and decimal dilutions for microbiological examination*

ISO 7218, *Microbiology of food and animal feeding stuffs—General requirements and guidance for microbiological examinations*

ISO 11133, *Microbiology of food, animal feed and water—Preparation, production, storage and performance testing of culture media*

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

ISO ба IEC-ийн стандартад ашиглах нэр томьёоны өгөгдлийн санг дараах хаягаас авч болно:

- IEC Electropedia: <http://www.electropedia.org/>
- ISO Онлайн хайлтын платформ: <http://www.iso.org/obp>

3.1

Listeria monocytogenes

энэ стандартын дагуу шинжилгээ хийхэд морфологи, физиологи, биохимийн тодорхой шинж үзүүлдэг, мөн хатуу сонгомол тэжээлт орчин дээр хэв шинжит колони үүсгэдэг бичил биетэн

3.2

***Listeria monocytogenes*-ийг илрүүлэх**

энэ стандартын дагуу шинжилгээ хийхэд, тухайн бүтээгдэхүүний масс эсвэл эзэлхүүн мөн тодорхой гадаргуу дээр *Listeria monocytogenes* (3.1) илэрч байгаа эсэхийг тодорхойлох

3.3

***Listeria* spp.**

энэ стандартын дагуу шинжилгээ хийхэд морфологи, физиологи, биохимийн тодорхой шинж үзүүлдэг, мөн хатуу сонгомол тэжээлт орчин дээр хэв шинжит колони үүсгэдэг бичил биетэн

3.4

***Listeria* spp.-ийг илрүүлэх**

энэ стандартын дагуу шинжилгээ хийхэд, тухайн бүтээгдэхүүний масс эсвэл эзэлхүүн мөн тодорхой гадаргуу дээр *Listeria* spp. (3.3) илэрч байгаа эсэхийг тодорхойлох

4 Аргын мөн чанар

4.1 Ерөнхий зүйл

Listeria spp. нь бага тоогоор байж болох ба ихэнхдээ их тооны бусад бичил биетэнтэй хамт байдаг тул сонгомол баяжуулалт хийх шаардлагатай байдаг. Түүнчлэн эхний сонгомол баяжуулалтын тэжээлт орчны дарангуйлагч бодисын агууламжийг бууруулж гэмтсэн эсвэл стресст орсон *Listeria* spp.-ийг илрүүлэх шаардлагатай.

ТАЙЛБАР: *L.monocytogenes* нь бусад *Listeria*-ийн зүйлүүд, тухайлбал *L.innocua* эсвэл *L. ivanovii*-тэй хамт илэрч болно.

Энэхүү стандартын хүрээнд *L.monocytogenes* ба *Listeria* spp.-ийг илрүүлэхдээ А хавсралтад заасан дараалсан дөрвөн үе шатыг шаарддаг.

4.2 Сонгомол бодисын концентрацийг бууруулсан сонгомол шингэн тэжээлт орчин (хагас-Фразер шөл)-д эхний баяжуулалт хийх

Шинжилгээний сорьц (9.1)-ыг шингэрүүлэх шингэн болох акрифлавин, налидиксийн хүчил агуулсан хагас сонгомол тэжээлт орчин (хагас-Фразер шөл, В.1-ийг үзэх)-д тарилга хийнэ. Эхний булингыг 30 °С температурт 24-26 цаг өсгөвөрлөнө.

4.3 Сонгомол бодис бүхий сонгомол шингэн тэжээлт орчин (Фразер шөл)-д хоёрдогч баяжуулалт хийх

4.2-т заасны дагуу илрүүлсэн өсгөврийг өтгөрүүлсэн хоёр дахь шингэн баяжуулах тэжээлийн орчин (Фразер шөл)-д тарина. Фразер шөлийг 37 °C температурт 24 цаг өсгөвөрлөнө.

4.4 Сонгомол хатуу тэжээлт орчинд тарих

4.2 болон 4.3-т заасны дагуу илрүүлсэн өсгөврийг дараах хоёр сонгомол хатуу тэжээлт орчинд тарина.

- Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агар (Ном зүй [16] ба [17] ба В.3-ыг үзэх);
- Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агар тэжээлт орчинтой ижил төрлийн сонгомол хатуу тэжээлт орчныг хэрэглэх бол тус тэжээлт орчноос нэгээс илүүгүй субстрат /эсвэл зарчмаар ялгаатай байна (В.4-ийг үзэх). Тэжээлт орчны талаарх мэдээллийг Е Хавсралтаас үзэх.

Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агар тэжээлт орчныг 37°C-д нийт 48 цаг өсгөвөрлөнө. Хэрэв *L.monocytogenes* эсвэл *Listeria* spp. гэж таамаглаж буй колони 24 цагийн дотор илэрвэл өсгөвөрлөлтийг энэ шатнаас зогсоож болно. Хоёр дахь сонгомол тэжээлт орчныг тохирох температурт өсгөвөрлөж, тохирох цаг хугацааны дараа шалгана.

4.5 Баталгаажуулах

L.monocytogenes эсвэл *Listeria* spp. гэж таамаглаж буй колонийг 4.4-д заасан тэжээлт орчинд өсгөвөрлөж, шаардлагатай морфологи /эсвэл биохимийн шинжилгээгээр баталгаажуулна.

5 Тэжээлт орчин, урвалж бодис

Лабораторийн үйл ажиллагаа, ISO 7218 болон ISO 11133-ыг үз.

Тэжээлт орчин, урвалж бодисын найрлага, тэдгээрийн бэлтгэлийг В хавсралтад тайлбарласан болно.

6 Тоног төхөөрөмж ба хэрэглэх зүйлс

Микробиологийн лабораторийн энгийн (ISO 7218-ийг үзэх) буюу дараах тоног төхөөрөмжийг ашиглана.

6.1 Хуурайгаар (хатаах шүүгээ) болон уураар ариутгах (автоклав) багаж

ISO 7218 стандартыг үзэх.

6.2 Хатаах шүүгээ эсвэл дулаан тогтоогуур, (25-50) °C температурт ажиллах чадвартай.

6.3 Дулаан тогтоогуур, (30±1) °C, (37±1) °C болон (25±1) °C-д (сонголтоор) тус тус ажиллах чадвартай.

6.4 Усан халаагуур, (47-50) °C температурт ажиллах чадвартай.

6.5 Ариун гогцоо, ойролцоогоор 3 мм голчтой эсвэл 10 μл эзлэхүүн бүхий тарилгын зүү эсвэл утас.

6.6 рН метр, 25 °C-д 0,01 нэгж хүртэл унших боломжтой, ± 0,1 рН нэгжийн утгыг нарийвчилах чадвартай.

6.7 Ариун хэмжээст шилэн эсвэл автомат соруур, 1 мл, 10 мл-ийн хуваарьтай

6.8 Ариун Петрийн аяга, жишээ нь 90 мм-ийн голчтой.

6.9 Микроскоп, гэрлийн ялгарал сайтай, тавиур шил болон бүрхүүл шилтэй

6.10 Хөргөгч, $(5 \pm 3) ^\circ\text{C}$ температурт ажиллах чадвартай.

7 Дээж авах

Дээж авах хэсэг нь энэ стандартын аргад заагаагүй. Хэрэв бүтээгдэхүүнээс дээж авах тусгай Олон улсын стандарт байхгүй бол талууд харилцан тохиролцохыг зөвлөж байна. Хүнс, малын тэжээлийн дээжийн хувьд ISO/TS 17728^[3] стандартыг үзэх. Орчны дээж авах бол ISO 18593^[2] стандартыг мөн Ном зүй [24]-ийг хэрэглэнэ. Лабораторийн шинжилгээнд бүтээгдэхүүнийг бүрэн төлөөлж чадахуйц, тээвэрлэлт, хадгалалтын явцад гэмтэж өөрчлөгдөхгүй дээжийг хүлээж авах шаардлагатай (ISO 7218 стандартыг үзэх).

8 Шинжилгээний дээж бэлтгэл

Тухайн бүтээгдэхүүнтэй холбоотой Олон улсын стандартын дагуу шинжилгээний дээжийг бэлтгэнэ [ISO 6887 (бүх хэсэг) ба ISO 18593^[2] стандартыг үзэх]. Хэрэв тусгай стандарт байхгүй бол талуудыг харилцан тохиролцохыг зөвлөж байна.

9 Шинжилгээний явц

9.1 Шинжлэгдэхүүний хэмжээ, эхний булинга

ISO 6887 (бүх хэсэг) болон шинжлэх бүтээгдэхүүнд тохирох Олон улсын стандартыг үзэх.

Эхний суспензийг бэлтгэхэд ерөнхий тохиолдолд В.1 (хагас-Фразер шөл)-д заасан баяжуулалтын өмнөх тэжээлийг шингэлэгч уусмалаар ашиглана.

Ерөнхийдөө эхний булингыг бэлтгэхийн тулд 25 г эсвэл 25 мл шинжигээний сорьцыг 225 г буюу 225 мл эхний сонгомол баяжуулах тэжээлт орчин (В.1)-днэмж шинжилгээний дээжийг 10 дахин шингэлэн нэгэн төрлийн болгоно. Эхний сонгомол баяжуулах тэжээлт орчин хэрэглэхийн өмнө тасалгааны хэмд байлгана.

Энэ стандарт нь 25 г бүхий дээжид баталгаажсан болно. Дээжийн бага хэмжээний сорьцыг ашиглан эхний баяжуулах шөл болон шинжилгээний дээжийн хоорондын харьцаа ижил байхаар нэмэлт баталгаажуулалт/ баталгаажилт хийлгүйгээр хэрэглэж болно. Хэрэв баталгаажуулалт /баталгаажилтын судалгаагаар *L.monocytogenes* эсвэл *Listeria* spp.-ийг илрүүлэхэд сөрөг нөлөөгүйг тогтоосон бол эхний баталгаажилтанд их хэмжээний сорьцыг ашиглаж болно.

1-Р ТАЙЛБАР: Баталгаажуулалтыг ISO 16140 (бүх хэсэг) стандартын зохих хэсгийн дагуу хийж болно^[1]. Дээжийг баталгаажуулахдаа ISO 6887-1:2017, D хавсралт (чанарын шинжилгээ хийх дээжийг нэгтгэн баталгаажуулах протокол)-д заасан протоколын дагуу хийнэ. *Listeria*-ийн нэгдлийн дээжийн тухай мэдээллийг Номзүй [21] ба [22]-ыг үзэх.

2-Р ТАЙЛБАР: Хэмжээ ихтэй тохиолдолд, дээжийн сорьцтой холихын өмнө эхний сонгомол баяжуулах тэжээлт орчинг $(30 \pm 1) ^\circ\text{C}$ хүртэл урьдчилан халаахыг зөвлөж байна.

9.2 Эхний баяжуулалт

9.1-ийн дагуу бэлтгэсэн эхний баяжуулалт бүхий тэжээлт орчин (хагас-Фразер шөл, В.1-ийг үзэх)-г 30°C (6.3)-д 25 ± 1 цаг өсгөвөрлөнө.

1-Р ТАЙЛБАР: Өсгөвөрлөлтийн явцад хар өнгө үүсдэг.

2-Р ТАЙЛБАР: Урьдчилан баяжуулсан дээжийг өсгөвөрлөсний дараа Фразер шөлрүү шилжүүлэхийн өмнө 5°C (6.10) температурт хамгийн ихдээ 72 цаг хадгалах боломжтой.

(Ном зүй [20]-г үзэх).

9.3 Хоёр дахь баяжуулалт

9.3.1 Эхний булинга (эхний баяжуулалт)-ыг 25 ± 1 цаг (9.2) өсгөвөрлөсний дараа, эхний баяжуулалт хийгдсэн 9.2 (түүний өнгө үл харгалзан)-ээс 0,1 мл-ийг 10 мл

хоёр дахь баяжуулах тэжээлт орчин (Фразер шөл) (B.2) бүхий хуруу шил эсвэл шилэн саванд шилжүүлж өсгөвөрлөнө.

9.3.1 Тарилт бүхий тэжээлт орчин (9.3.1)-г 37 °C (6.3) температурт 24±1 цаг өсгөвөрлөнө.

ТАЙЛБАР: *Listeria monocytogenes*-ээс бусад *Listeria* spp.-ийн зүйлүүдийг илрүүлэхдээ бүрэн сэргээх зорилгоор дахин 24 цаг өсгөвөрлөнө.

9.4 Сэлгүүлэн тарих, тодорхойлох

9.4.1 Ерөнхий

9.4.1.1 30 °C (6.3) температурт 25±1 цаг өсгөвөрлөсөн эхний баяжуулалтын өсгөврөөс (9.2) эхний сонгомол хатуу тэжээлт орчин болох Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агарын гадаргууд гогцоо (6.5) зүүгээр тарилт хийж, цэвэр тусгаар колони гаргаж авна.

Дурын хоёр дахь сонгомол тэжээлт орчин (B.4)-д ижил аргаар тарилт хийнэ.

ТАЙЛБАР: Хагас-Фразер ба Фразерийн шөлийг ялгах сонгомол тэжээлт орчин руу шилжүүлэхийн өмнө хөргөгчинд 5 °C (6.10) температурт хамгийн ихдээ 72 цаг хадгалах боломжтой [20].

9.4.1.2 Хоёр дахь баяжуулалтыг 37 °C (6.3)-д 24±2 цаг (9.3.2) өсгөвөрлөсний дараа сонгомол тэжээлт орчинд 9.4.1.1-д заасны дагуу давтан тарилга хийнэ.

9.4.1.3 9.4.1.1 болон 9.4.1.2-т тарилт хийсэн Петрийн аяга бүхий Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агар (B.3)-ыг 37 °C (6.3) температуртай дулаан тогтоогуурт доош харуулан байрлуулна. Хоёр дахь сонгомол тэжээлт орчны (B.4) хувьд, үйлдвэрлэгчийн зааврыг дагана.

9.4.1.4 Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агарыг нийт 48±2 цаг өсгөвөрлөнө. Хэрэв *L.monocytogenes* эсвэл *Listeria* spp. гэж таамаглаж буй колони 24±2 цагт илэрвэл тус шатанд өсгөвөрлөлтийг зогсоож болно. Хоёр дахь сонгомол агарыг тохирох хугацаанд өсгөвөрлөнө. *L.monocytogenes* эсвэл *Listeria* spp. гэж таамаглаж буй колони байгаа эсэхийг (9.4.1.3) шалгана.

ТАЙЛБАР: Өсгөвөрлөсний дараа үр дүнг уншихийн өмнө аягыг хөргөгчинд 5 °C (6.10) температурт хамгийн ихдээ 48 цаг хадгалах боломжтой.

9.4.2 Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агар

Тунгалаг хүрээтэй хөх-ногоон колони (ердийн колони)-ийг *L.monocytogenes* гэж таамаглана. *L..ivanovii*-ийн колони мөн тунгалаг хүрээтэй хөх-ногоон колони байдаг. *Listeria* spp. гэж таамаглах колони нь тунгалаг хүрээтэй буюу хүрээгүй хөх-ногоон өнгөтэй байдаг.

1-Р ТАЙЛБАР: *L.monocytogenes*-ийн зарим омгууд нь стрессд орсноор ялангуяа хүчлийн стрессд орсноор маш сул хүрээ (эсвэл бүр ямар ч хүрээгүй) үүсгэдэг.

2-Р ТАЙЛБАР: Зарим ховор *L.monocytogenes* нь PIPLC (фосфатидилинозитолфосфолипаза C)-ийн сул идэвхи үзүүлдэг. Ийм бичил биетний өсгөвөрлөлтийг жишээлбэл, дөрвөн өдөр хүртэл хугацаагаар сунгаж илрүүлнэ.Эдгээр омгийн зарим нь өвчин үүсгэгчид байж болно^[13]. *L.monocytogenes*-ийн ямар ч омог PIPLC сөрөг гэж тэмдэглэгдээгүй.

3-Р ТАЙЛБАР: *Listeria* spp.-ээс бусад организм дээрх тэжээлт орчинд цэнхэр колони үүсгэдэг. В хавсралт ба Ном зүй [23]-г үзэх.

9.4.3 Хоёр дахь сонгомол тэжээлт орчин

Хэрэглэсэн тэжээлт орчны хэлбэр, түүний онцлогт суурилан (B.4) *Listeria* spp. эсвэл *L.monocytogenes* гэж таамаглаж буй колони ургасан эсэхийг тохиромжтой хугацааны дараа шалгана. Дэлгэрэнгүй мэдээллийг E хавсралтаас үзэх.

9.5 *L.monocytogenes* эсвэл *Listeria* spp. гэж батлах

9.5.1 Батлах сорилд колони сонгох

9.5.1.1 *L.monocytogenes*-ийг батлахын тулд *L.monocytogenes* гэж тооцогдох дор хаяж нэг колонийг (9.4.2 ба 9.4.3-ыг үзэх) сонгоно. Дээж бүрээс нэг колони сонгоход хангалттай. Эхний колони сөрөг байвал, сонгомол тэжээлт орчин

(сонгомол тэжээлт орчин бүхий аяга тус бүрээс хамгийн ихдээ 5 колони)-оос *L.monocytogenes* гэж тооцсон колонийг дахин сонгож авна.

Сонгосон колонийг сонгомол бус урьдчилан хатаасан тэжээлт орчны гадаргууд зурааслан тарьж, тухайлбал цустай агар, нутрейнт агар, триптон шар буурцаг дрожжийн хандтай агар (TSYEA) (B.14) зэрэгт тусгаар колони гаргаж авна.

Цэвэр өсгөвөр гаргаж авахад цустай агарыг хэрэглэх нь гемолизийн сорил эерэг өсгөвөр ялгах боломж олгодог (9.5.2.5.2 ба D хавсралтыг үзэх). Хэрэв цустай агар дээр гемолизийн хүрээ илрээгүй бол гемолизийн сорилыг хатгах аргаар (9.5.2.5.2) эсвэл шингэн орчинд (9.5.2.5.3) тарих замаар гүйцэтгэнэ.

Тарилт бүхий аягыг 37 °C (6.3) температурт 18-24 цаг эсвэл хангалттай өсөлттэй болох хүртэл өсгөвөрлөнө.

Хэрэв колони ялгагдаагүй бол *L.monocytogenes*-ийн хэв шинжит колонийг өөр сонгомол бус агар бүхий аяганаас сонгоно. Сонгомол бус агараас цэвэр колони сонгож дараах шинжилгээг (9.5.2) гүйцэтгэнэ.

9.5.1.2 *Listeria* spp.-ийг батлахын тулд *Listeria* spp. гэж тооцогдох дор хаяж нэг колонийг (9.4.2 ба 9.4.3-ыг үзэх) сонгоно. Эхний колони нь сөрөг байвал, сонгомол тэжээлт орчин(сонгомол тэжээлт орчин бүхий аяга тус бүрээс хамгийн ихдээ 5 колони)-оос *Listeria* spp. гэж тооцсон колонийг дахин сонгож авна.

Listeria spp.-ийг баталгаажуулахдаа TSYEA тэжээлт орчинг ашиглана.

Сонгосон колонийг урьдчилан хатаасан TSYEA (B.14) тэжээлт орчны гадаргууд зурааслан тарьж тусгаар колони гаргаж авна.

Тарилт бүхий аягыг 37 °C (6.3) температурт 18-24 цаг эсвэл хангалттай өсөлттэй болох хүртэл өсгөвөрлөнө.

TSYEA тэжээлт орчин дээрх *Listeria* spp.-ийн хэв шинжит колони нь 1-2 мм диаметртэй, гүдгэр, өнгөгүй, тунгалаг захтай байна. Тарилт бүхий аягыг 45 градусын өнцөгт гэрэл (хиймэл буюу байгалийн)-д харвал, колони нь хөх саарал өнгөтэй, мөхлөгт гадаргуутай харагддаг.

9.5.2 *L.monocytogenes*-ийг батлах

9.5.2.1 Ерөнхий

L.monocytogenes-ийг батлах сорилыг гүйцэтгэнэ. Батлах сорил бүрт тохирох эерэг ба сөрөг хяналтын омгийг хэрэглэнэ.

1 дүгээр хүснэгтэд жагсаасан (тодоор бичсэн) заавал шаардлагатай сорилыг гүйцэтгэнэ.

1-р хүснэгт – *L.monocytogenes*-ийг батлах сорил

Сорил	<i>L.monocytogenes</i> -ийг батлах сорил	Үр дүн
Заавал шаардлагатай	Микроскопийн шинжилгээ ^a (9.5.2.4)	Богино нарийн савханцар эсвэл коккобацил
	Бета-гемолиз (9.5.2.5)	+
	L-Рамноза (9.5.2.7)	+
	D-Ксилоза (9.5.2.7)	-
Сонголтоор	Каталазын сорил (9.5.2.2)	+
	25 °C температурт хөдөлгөөн (9.5.2.3)	+
	КАМП сорил (9.5.2.6)	+
^a Оттавиани, Агостийн зааврын дагуу <i>Listeria</i> -ийн агар хэрэглэсэн мөн хоёр дахь сонгомол тэжээлт орчин нь өвчин үүсгэгч болон өвчин үүсгэдэггүй <i>Listeria</i> spp.-ийг ялгадаг тохиолдолд микроскопийн шинжилгээг сонголтоор хэрэглэнэ.		

Батлах сорилын үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг D хавсралтаас үзэх.
ТАЙЛБАР: Ялгасан *Listeria monocytogenes*-ийн өсгөврийг батлахдаа ISO 7218 стандартад дурьдсан аргачлалыг ашиглаж болно.

Хэрэв үр дүн баталгаатай гэж үзвэл *Listeria monocytogenes*-ийн биохимийн шинжийг таних цомгийг ашиглаж болно (ISO 7218 стандартыг үзэх).

L.monocytogenes-ийн зарим ховор омгууд нь энэ стандартад заасан нөхцлийн дагуу бета-гемолизийн хүрээ эсвэл КАМП сорилд эерэг үр дүн үзүүлдэггүй. Хэрэв RIPLC сул идэвхтэй зүйлүүд нь Оттавиани, Агостийн зааврын дагуу Листериа агар дээр гемолизийн хүрээ үүсгэдэггүй хэв шинжит колони байвал *L.monocytogenes* мөн эсэхийг тодорхойлох нэмэлт сорил (Грамын будаг, каталазын сорил, хөдөлгөөн, КАМП сорил, PCR зэрэг) хийхийг зөвлөж байна.

9.5.2.2 Каталазын сорил (сонголтоор)

9.5.1.1-т заасны дагуу ялгасан колонийг авч, тавиур шилэн дээр нэг дусал устөрөгчийн хэт ислийн уусмал (В.6)-тай холино. Нэн даруй хийн бөмбөлөг үүсэх нь эерэг урвалыг харуулна.

ТАЙЛБАР: Цустай агараас ялгасан колони нь заримдаа каталазын урвалд хуурамч-эерэг үр дүн өгдөг.

9.5.2.3 Хөдөлгөөний сорил (сонголтоор)

9.5.1.1-т заасны дагуу ялгасан колонийг авч, сонгомол бус шингэн тэжээлт орчин бүхий хуруу шилэнд суспензлэнэ.

25 °C температуртай дулаан тогтоогуур (6.3)-т 8-24 цаг тэжээлт орчинд булинга үүстэл өсгөвөрлөнө.

Дээрх өсгөврөөс гогцоо зүү (6.5) ашиглан нэг дуслыг авч микроскопийн цэвэр тавиур шилэн дээр байрлуулна. Дээд талд нь бүрхүүл шил байрлуулан микроскоп (6.9)-оор харна.

Listeria spp. (*L.monocytogenes* мөн хамаарна) нь тонгорох хөдөлгөөнтэй нарийн, богино савханцар харагдана.

Өсгөврийг 25 °C-ээс дээш температурт өсгөвөрлөж байгаа тохиолдолд энэ хөдөлгөөнийг үзүүлдэггүй. Үүнийг *Listeria*-ийн мэдэгдэж буй өсгөвөртэй харьцуулж үзнэ. Кокк, том савханцар, эсвэл түргэн сэлэх хөдөлгөөнтэй савханцар нь *Listeria* spp. биш юм.

Хөдөлгөөн тодорхойлох өөр сорилын хувьд тарилгын зүү (6.5) ашиглан сонгомол бус агараас ялгасан колоний хэсгийг ариун ус (эсвэл бусад тохиромжтой шингэлэгч)-аар шингэлж хэрэглэнэ. *Listeria* spp. (*L.monocytogenes* мөн хамаарна) нь тонгорох хөдөлгөөнтэй нарийн, богино савханцар харагдана.

Мөн өөр сорилын хувьд, тарилгын зүү (6.5) ашиглан 9.5.1.1-д ургасан хэв шинжит колониос авч хөдөлгөөн тодорхойлох агар (В.7)-т хатгаж тарина. 25 °C температурт 48 ± 2 цаг өсгөвөрлөнө.

Хатгалтын эргэн тойронд ургалтыг шалгана. *Listeria* spp. нь хөдөлгөөн нь шүхэр хэлбэрийн ургалт үзүүлдэг. Хэрэв өсөлт хангалтгүй байвал 5 хоног хүртэл өсгөвөрлөн хатгалтыг дахин ажиглана.

ТАЙЛБАР: *Listeria*-ийн зарим шинэ зүйл саяхан ялгагдсан байна. [5], [10], [12], [14], [25], [26], [27] Тэдгээрийн ихэнх нь хөдөлгөөн тодорхойлох агар дээр хөдөлгөөнгүй байна.

9.5.2.4 Микроскопийн шинжилгээ (сонголтоор өвчин үүсгэгч *Listeria* spp. илрүүлэх тусгай агарыг хэрэглэсэн тохиолдолд)

9.5.1.1-д ургасан цэвэр тусгаар колонийг авч, микроскопийн бэлдэц (Грамын будаг зэрэг) бэлтгэнэ. *Listeria* spp. (*L.monocytogenes* мөн хамаарна) нь шинэ өсгөврөөс бэлтгэсэн бол тонгорох хөдөлгөөнтэй, Грам эерэг (хэрэв Грамын будалт хийсэн бол), нарийн, богино савханцар эсвэл коккобацил харагдана.

Грамын будаг бүхий микроскопийн бэлдэц хийх аргыг ISO 7218 стандартаас үзэх.

9.5.2.5 Гемолизийн сорил

9.5.2.5.1 Ерөнхий

Дараах гемолизийн сорилуудын аль нэгийг сонгоно (9.5.2.5.2 эсвэл 9.5.2.5.3).

ТАЙЛБАР: Энэ стандартад заасан нөхцөлд *L.monocytogenes*-ийн зарим ховор омгууд b-гемолиз эсвэл КАМП сорилд эерэг дүн үзүүлдэггүй.

9.5.2.5.2 Цустай агарт гемолиз үүсгэх

Морфологи, физиологийн шинж нь *Listeria* spp. гэж тодорхойлогдож байвал цустай агар бүхий аяга (B.8)-нд тарьж гемолизийн урвалыг тодорхойлно.

Хэрэглэхийн өмнө агарын гадаргууг сайтар хатаана. 9.5.1.1-ээс ялгасан колонийг авч, тэжээлт орчны хэсэгт зүү (6.5)-гээр тарина. Энэ тарилтыг өсгөвөр бүрт давтана. Хэрэв боломжтой бол, нэг аяган дээр эерэг (*L.monocytogenes*) болон сөрөг (*L.innocua*) хяналтын өсгөврийг тарина. Жишээ нь: *L.monocytogenes* 4b WDCM 00021 эсвэл *L.monocytogenes* 1/2a WDCM 00109, *L.innocua* WDCM 00017 зэргийг ашиглаж болно.

Шинжилгээний болон хяналтын омгийг 37 °C (6.3) температурт 24±2 цаг өсгөвөрлөсний дараа шалгана. *L.monocytogenes* нь гемолизийн нарийн, тунгалаг, цайвар бүс үзүүлдэг; харин *L.innocua* нь тарилтын эргэн тойронд тунгалаг хүрээ үзүүлдэггүй. *L.seeligeri* нь ихэвчлэн гемолизийн идэвхи сул хүрээ үзүүлдэг. *L.ivanovii* нь ихэвчлэн гемолизийн зураас бүхий хүрээ сайн үзүүлдэг. Шинжилгээний өсгөврийг хяналттай харьцуулахдаа тод гэрэлд өсгөвөрлөлтийг харж шалгана.

1-Р ТАЙЛБАР: Гемолизийн урвал нь тарилтын эргэн тойронд тэжээлт орчны гадаргуу дээр тунгалаг хүрээ үүссэнээр илүү амархан танигдана.

2-Р ТАЙЛБАР: Гемолизийн сорилыг КАМП тестийн шинжилгээнд ашигладаг цустай агар тэжээлт орчинд тарьж болно.

9.5.2.5.3 Цусны улаан эсийг ашигладаг гемолизийн урвал

Цусны улаан эсийг ашиглан дараах байдлаар гемолизийн урвал явагдаж болно.

150 μл сонгомол бус шингэн тэжээлт орчинд колонийг суспензэлж, 37°C (6.3)-д 2 цаг өсгөвөрлөнө. Дараа нь 150 μл цусны улаан эсийн булинга (B.10)-ыг нэмнэ. Үүнийг 37 °C (6.3)-д 15-60 минут өсгөвөрлөсний 5 °C (6.10)-д ойролцоогоор 2 цаг хөргөж, гемолизийн идэвхийг шалгана. Хэрэв урвал эргэлзээтэй байвал, 5 °C (6.10)-д 24±2 цаг хүртэл байлгана. Цусны улаан эсийн тунадас (хуруу шилний ёроолд улаан цэг үүсэх) нь сөрөг урвалыг илэрхийлдэг.


Эерэг ба сөрөг хяналтыг шалгана. Хяналтын омгийг 9.5.2.5.2-оос үзэх.

9.5.2.6 КАМП сорил (сонголтоор)

Хэрэв гемолизийн шинжилгээний үр дүнг тайлбарлахад төвөгтэй байвал, гемолизийг листериолизиний идэвхитэй холбоотойгоор КАМП сорилыг гүйцэтгэхийг зөвлөж байна.

β-гемолиз үүсгэдэг *Staphylococcus aureus* (жишээ нь: WDCM 00034) ба *Rhodococcus equi* (жишээ нь: WDCM 0028)-ийн омгоор КАМП сорилыг гүйцэтгэх шаардлагатай. *S.aureus*-ийн бүх омог нь КАМП сорилд тохиромжтой байдаггүй. *S.aureus*, *R.equi*-ийн өсгөвөр бүрийг цустай агар тэжээлт орчинд (B.8.3 эсвэл B.11.4) дан зураасаар, хоёр өсгөвөр хоорондоо параллель байхаар (1-р зургийг үзэх) тарина. Тарилтыг нарийхан жигд хийх шаардлагатай.

Шинжилгээний өсгөвөр (9.5.1.1)-ийг *S.aureus*, *R.equi*-ийн өсгөвөртэй тэгш өнцөгтэй, мөн босоогоор тарьсан өсгөвөрт хүрэлцэхээргүй ойролцоогоор 1-2 мм зайтай зураасаар тарина. Нэг аяган дээр хэд хэдэн туршилтын өсгөвөр тарьж болно.



1-Р ЗУРАГ: КАМП сорилын аяган дээрх тарилт ба түүний тайлбар

Энд:

1 β-гемолизийн нарийн хүрээ

- 2 β -гемолизийн нарийн хүрээ үүсгээгүй
- 3 β -гемолизийн нарийн өргөн хүрээ
- 4 *L. monocytogenes*
- 5 *L. innocua*
- 6 *L. ivanovii*

1-р зурагт үзүүлсэн босоо шугам нь *S.aureus* (S), *R.equi* (R)-ийн зураасыг илэрхийлнэ. Хэвтээ шугам нь шинжилгээний өсгөврүүдийг илэрхийлнэ. Торлосон хэсгүүд нь гемолиз хүрээ үүссэнийг заана. Тасархай зураасаар *S.aureus*-ийн өсгөврийн нөлөөлсөн хүрээг үзүүлнэ.

Мөн *L.monocytogenes*, *L.innocua*, *L.ivanovii*-ийн хяналтын өсгөврүүдийн тарилт байна. Тухайлбал *L.monocytogenes* 4b WDCM 00021, *L.monocytogenes* 1/2a WDCM 00109, *L.innocua* WDCM 00017, *L.ivanovii* WDCM 00018 зэргийг ашиглаж болно. ISO 11133 стандартад заасны дагуу хяналтын нөөц өсгөврүүдийг хадгалана.

Цустай агар (B.8.3) хэрэглэж байгаа бол 37 °C температурт 18-24 цаг өсгөвөрлөнө. Хэрэв давхар савласан цустай агар тэжээлт орчин (B.11.4) ашиглаж байгаа бол 37 °C температурт 12-18 цаг өсгөвөрлөнө.

R.equi-ийн эерэг урвал нь "сумны толгой" хэлбэрийн гемолизийн өргөн хүрээтэй (5-10 мм) харагддаг. Хэрвээ гемолизийн наргийн хүрээ нь *R.equi*-ийн тархалтын хүрээтэй шинжилгээний өсгөврийн огтлолцол 1 мм-ээс хэтрээгүй байвал урвалыг сөрөг гэж үзнэ.

S.aureus-ийн эерэг урвал гэдэг нь *S.aureus* өсгөврийн ургалтаас шалтгаалсан сул гемолитик хүрээнд шинжилгээний омогоос 2 мм орчим өргөн гемолизын жижиг хүрээ үзэгдэнэ. *S.aureus* болон *L.monocytogenes*-ийн хэсэгт гемолизын өргөн хүрээ нь үүсдэггүй.

9.5.2.7 Нүүрс ус ашиглах

Гогцоо зүү (6.5) ашиглан сонгомол бус агар (9.5.1.1)-аас ялгасан өсгөврийг нүүрс ус агуулсан шөлөнд (B.12) тарина. 37 °C температурт өсгөвөрлөнө. Ихэвчлэн микро хэмжээст хуруу шилэнд 24-48 цаг, макро хэмжээст хуруу шилэнд 5 хоногийн дараа эерэг урвал (хүчил үүснэ) шар өнгөөр илэрнэ. L-Рамноза эерэг, D-Ксилоза сөрөг (D хавсралтыг үзэх) шинжээр нь дээрх хоёр нүүрс усыг *L.monocytogenes*-ийг батлахад ашигладаг.

ТАЙЛБАР: *L.monocytogenes*-ийн ховор омгууд L-Рамнозаг исэлдүүлдэггүй.^{[15], [18]}

Микро хэмжээст хуруу шил ашигласан тохиолдолд хариу урвал илүү хурдан байдаг. Нийт эзэлхүүнтэй харьцуулахад тарилтын түвшин чухал хүчин зүйл болдог. Сонгосон протокол бүрийн хувьд, шар өнгө үүссэн хугацааг баталгаажуулах нь чухал. Үүнийг хянаж ажиллахыг зөвлөж байна. Жишээ нь: *L.monocytogenes* 4b WDCM 00021, *L.innocua* WDCM 00017 ба *L.ivanovii* WDCM 00018 зэргийг ашиглаж болно. ISO 11133 стандартад заасны дагуу хяналтын өсгөвөрийг хадгална.

9.5.3 *Listeria* spp.-ийг батлах

9.5.3.1 Ерөнхий

Хэв шинжит колони (9.5.1.2)-оос *Listeria* spp.-ийг батлах сорилыг гүйцэтгэнэ. Баталгаажуулах туршилт бүрт тохирох эерэг ба сөрөг хяналтын омгийг хэрэглэнэ.

2-р Хүснэгтэнд жагсаасан (тодоор бичсэн) заавал шаардлагатай сорилыг хийж гүйцэтгэнэ.

Хэрэв *Listeria* spp.-ийн зүйлийг тодорхойлох шаардлагатай бол, цаашид хийх сорилыг D хавсралтаас үзэх.

2-р хүснэгт: *Listeria* spp.-ийг батлах сорил

Сорил	<i>L.monocytogenes</i> -ийг батлах сорил	Үр дүн
Заавал шаардлагатай	Микроскопийн шинжилгээ (9.5.2.4) Каталазын сорил (9.5.2.2)	Богино нарийн савханцар эсвэл коккобацил +

Сонголтоор	VP сорил(9.5.3.5) 25 °C температурт хөдөлгөөн (9.5.2.3)	+ +
------------	--	--------

1-Р ТАЙЛБАР: Ялгасан *Listeria spp.*-ийн өсгөврийг батлахдаа ISO 7218 стандартад дурьдсан өөр аргачлалыг ашиглаж болно.

2-Р ТАЙЛБАР: Шинээр ялгасан *Listeria spp.*-ийн зарим шинэ зүйл нь энэхүү схемийн хөдөлгөөн, VP сорил, 37 °C температурт өсөх (тухайлбал: Номзүй [4], [10], [25], [26] ба [27]-г үзэх) зэрэг шинжтэй тохирохгүй байж болно.

9.5.3.2 Каталазын сорил

9.5.1.2-т ялгасан колонийг авч 9.5.2.2-т заасны дагуу шинжилгээг гүйцэтгэнэ.

9.5.3.3 Хөдөлгөөний сорил (сонголтоор)

9.5.1.2-т ялгасан колонийг авч 9.5.2.3-т заасны дагуу шинжилгээг гүйцэтгэнэ.

9.5.3.4 Вогес–Проскауерын (VP) сорил (сонголтоор)

Гогцоо зүү (6.5) ашиглан 3 мл VP-ийн орчин (B.13.1) бүхий хуруу шилэнд тарина. 37 °C температурт 24 ± 2 цаг өсгөвөрлөнө. Өсгөвөрлөсний дараа 0,6 мл 5 %-ийн α-нафтолын уусмал (B.13.2) ба 0,2 мл 40 %-ийн калийн гидроксидын уусмал (B.13.3)-ыг тус тус нэмнэ. Сайн сэгсэрч хуруу шилийг налуу (агаарын шингэний уулзварын талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор) байрлуулна. 15 минутаас 1 цагийн дараа үр дүнг шалгана. Эерэг урвал нь тод улаан өнгөөр илэрнэ. *Listeria spp.* нь VP сорилд эерэгүр дүн үзүүлнэ.

ТАЙЛБАР: *Listeria*-ийн зарим шинэ зүйл саяхан ялгагдсан байна. [5], [10], [12], [14], [25], [26], [27] Тэдгээрийн ихэнх нь VP сорилд сөрөг байна.

10 Морфологи, физиологийн шинж ба биохимийн урвалыг тайлбарлах

Listeria spp.-ийн бүх зүйл нь каталазын сорилд эерэг, жижиг, Грам эерэг савханцар эсвэл коккобацил байдаг.

L.monocytogenes-ийг 1 дүгээр хүснэгтийн дагуу, *Listeria spp.*-ийг 2 дугаар хүснэгтийн дагуу баталгаажуулна.

11 Ялгасан өсгөврийн нэмэлт шинж (сонголтоор)

L.monocytogenes гэж үзэж буй өсгөвөр (9.6)-ийг хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний буюу бүсийн *Listeria*-ийн Лавлагаа Лаборатори эсвэл (боломжгүй тохиолдолд) *Listeria*-ийн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Хамтын Ажиллагааны Төв зэрэгт нарийвчлан шинжлүүлнэ. Илгээхдээ өсгөвөртэй холбоотой бүхий л боломжит мэдээллийг дагалдуулна.

Хэрэв *Listeria*-ийн зүйлийг тодорхойлох шаардлагатай бол, цаашид хийх сорилыг D хавсралтаас үзэх.

12 Үр дүнг илэрхийлэх

Дээжийн хэсэг бүрт эсвэл гадаргуугийн сантиметр квадратад, шинжилсэн дээжийн миллилитр дэх эзлэхүүн, грамм дах массыг тодорхойлоход шинжилгээний сорьцод *L.monocytogenes* илэрсэн, илрээгүйг /эсвэл *Listeria spp.*-ийн илэрсэн, илрээгүй үр дүнг тайлбарласны дагуу (9.6-г үзэх) тайлагнана.

13 Аргын гүйцэтгэлийн шинж чанар

13.1 Аргын баталгаажилтын судалгаа

Аргын гүйцэтгэлийн шинж чанарыг лаборатори хоорондын шинжилгээгээр өвөрмөц чанар, мэдрэг чанар, мөн боломжтой бол аргын илрүүлэх түвшин (LOD₅₀)-г тодорхойлно. Энэ өгөгдлийг F хавсралтад нэгтгэн үзүүлэв. Лаборатори

хоорондын судалгаанаас гарсан утгууд E хавсралтад зааснаас өөр төрлийн хүнсний бүтээгдэхүүнд хамаарахгүй.

13.2 Мэдрэг чанар

Аргын мэдрэг чанар нь тухайн бохирдлын түвшинд шинжилсэн сорьцын тоог эерэг дээжийн тоонд хувааж тодорхойлно. Үр дүн нь дээжийн бохирдлын түвшнээс шууд хамаарна.

13.3 Өвөрмөц чанар

Аргын өвөрмөц чанар нь хоосон дээжийн тоог сөрөг гарсан дээжийн тоонд хувааж тодорхойлогдоно.

14 Илрүүлэх түвшин (LOD₅₀)

LOD₅₀ (илрүүлэх түвшин) гэдэг нь 50 %-ийн илрүүлэх магадлалын концентраци (cfu/шинжилгээний сорьц) юм.

15 Шинжилгээний тайлан

Шинжилгээний тайлан нь хэрэглэсэн арга болон гарсан үр дүнг заана. Түүнчлэн энэ стандартад ороогүй үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл, эсвэл үр дүнд нөлөөлж болзошгүй аливаа тохиолдлын талаар нарийвчлан тайлбарласан байх шаардлагатай (10 дугаар зүйлийг үзэх).


Шинжилгээний тайланд дээжийг бүрэн танихад шаардлагатай бүх мэдээллийг оруулна.

16 Чанарын баталгаа

Лаборатори нь шинжилгээ хийхэд тохирох тоног төхөөрөмж, бодис урвалж, арга техникийн чанарын хяналтын тогтолцоог сайтар тодорхойлсон байх шаардлагатай. Эерэг, сөрөг, хоосон хяналтыг ашиглах нь шинжилгээний нэг хэсэг юм. Тэжээлт орчны гүйцэтгэлийн шинжилгээг B.5 ба ISO 11133 стандартад тодорхойлсон.

А Хавсралт (норматив)

Шинжилгээний явцын бүдүүвч



А.1 зураг – Шинжилгээний явцын бүдүүвч

В Хавсралт (норматив)

Тэжээлт орчин ба урвалж бодисын найрлага, бэлтгэл

В.1 Эхний сонгомол баяжуулах шингэн тэжээл: хагас-Фразер шөл

В.1.1 Тэжээлийн суурь

В.1.1.1 Найрлага

Махны пептон	5,0 г
Казейны фермент	5,0 г
Махны ханд	5,0 г
Дрожжийн ханд	5,0 г
Натрийн хлорид	20,0 г
Хоёр халаат фосфат натрийн давс	12,0 г
Нэг халаат фосфат калийн давс	1,35 г
Эскулин	1,0 г
Ус	1000 мл

В.1.1.2 Бэлтгэл

Хуурайшуулсан бэлэн суурь болон тэжээлийн суурийн орц бүрийг усанд хийж, шаардлагатай бол халааж уусгана.

Шаардлагатай тохиолдолд ариутгасны дараа, рН-ийг 25 °С температурт $7,2 \pm 0,2$ болгож тохируулна.

Шинжилгээнд шаардагдах хэмжээтэй тохирох агууламж (9.1-ийг харах) бүхий хуруу шилэнд тэжээлт орчинг хуваарилна.

Автоклав (6.1)-т 121 °С температурт 15 минут ариутгана.

Ариутгахын өмнө хлорт литийн уусмал (В.1.2) болон налидиксийн хүчлийн уусмал (В.1.3)-ыг тэжээлт орчны суурь (В.1.1)-нд нэмж болно.

В.1.2 Хлорт литийн уусмал

В.1.2.1 Найрлага

Хлорт лити	3 г
Ус	10 мл

В.1.2.2 Бэлтгэл

Хлорт литийг усанд уусгана.

0,45 μm нүхтэй мембранаар шүүж ариутгана.

АНХААРУУЛГА — Хлорт литийг усанд уусгахдаа, тус урвал нь ихээхэн эксотермик шинжтэй учир бүхий л урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана. Түүнчлэн энэ уусмал нь салст бүрхэвчийг цочирдуулдаг.

В.1.3 Налидиксийн хүчлийн натрийн давсны уусмал

В.1.3.1 Найрлага

Налидиксийн хүчлийн натрийн давс	0,1 г
Натрийн гидроксид, 0,05 моль/л уусмал	10 мл

В.1.3.2 Бэлтгэл

Налидиксийн хүчлийн давсыг натрийн гидроксидод уусгана.

0,45 μm нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.1.4 Акрифлавины гидрохлоридын уусмал

В.1.4.1 Найрлага

Акрифлавины гидрохлорид	0,25 г
Натрийн гидроксид, 0,05 моль/л уусмал	100 мл

В.1.4.2 Бэлтгэл

Акрифлавины гидрохлоридыг усанд уусгана. 0,45 μ м нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.1.5 Аммонийн төмөр (III) цитратын уусмал

В.1.5.1 Найрлага

Аммонийн төмөр (III) цитрат	5,0 г
Ус	100 мл

В.1.5.2 Бэлтгэл

Аммонийн төмөр (III) цитратыг усанд уусгана. 0,45 μ м нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.1.6 Нийлмэл тэжээлт орчин

В.1.6.1 Найрлага

Тэжээлийн суурь (В.1.1)	100 мл
Хлорт литийн уусмал (В.1.2)	1,0 мл
Налидиксийн хүчлийн натрийн давсны уусмал (В.1.3)	0,1 мл
Акрифлавины гидрохлоридын уусмал (В.1.4)	0,5 мл
Аммонийн төмөр (III) цитратын уусмал (В.1.5)	1,0 мл

В.1.6.2 Бэлтгэл

Хэрэглэхийн өмнө нэн даруй дөрвөн уусмал (В.1.2-В.1.5) тус бүрийг 100 мл тэжээлийн суурь (В.1.1) дээр нэмнэ.

В.2 Хоёр дахь сонгомол баяжуулах шингэн тэжээл: Фразер шөл

В.2.1 Тэжээлийн суурь

В.2.1.1 Найрлага

Махны пептон	5,0 г
Казейны фермент	5,0 г
Махны ханд	5,0 г
Дрожжийн ханд	5,0 г
Натрийн хлорид	20,0 г
Хоёр халаат фосфат натрийн давс	12,0 г
Нэг халаат фосфат калийн давс	1,35 г
Эскулин	1,0 г
Литиум хлорид	3,0 г
Налидиксийн хүчлийн натрийн давс	0,02 г
Ус	1000 мл

В.2.1.2 Бэлтгэл

Хуурайшуулсан бэлэн суурь болон тэжээлийн суурийн орц бүрийг усанд хийж, шаардлагатай бол халааж уусгана.

Шаардлагатай тохиолдолд ариутгасны дараа, рН-ийг 25 $^{\circ}$ С температурт $7,2 \pm 0,2$ болгож тохируулна.

Шинжилгээнд шаардагдах хэмжээтэй тохирох агууламж бүхий хуруу шилэнд тэжээлт орчинг хуваарилна.

Автоклав (6.1)-т 121 °C температурт 15 минут ариутгана.

В.2.2 Акрифлавины гидрохлоридын уусмал

В.1.4-ийг харах.

В.2.3 Аммонийн төмөр (III) цитратын уусмал В.1.5-ыг харах.

В.2.4 Нийлмэл тэжээлт орчин

Хэрэглэхийн өмнө, тэжээлийн суурь (В.2.1) бүхий хуруу шил (10 мл эзлэхүүн) бүрт 0,1 мл хэмжээтэй В.2.2, В.2.3 уусмалыг нэмнэ. Зөөлөн холино.

В.3 Оттавиани, Агостийн зааврын дагуу *Listeria*-ийнагар^{[16],[17]}

В.3.1 Тэжээлийн суурь

В.3.1.1 Найрлага

Махны пептон	18 г
Казейны фермент	6 г
Дрожжийн ханд	10 г
Натрийн пируват	2 г
Глюкоза	2 г
Магнийн глицерофосфат	1 г
Магнийн сульфат (усгүй)	0,5 г
Натрийн хлорид	5,0 г
Хоёр халаат фосфат натрийн давс(усгүй)	2,5 г
5-бром-4-хлор-3-индолил-β-D-глюкопиранозид	0,05 г
Агар	9 - 18 г ^a
Ус	930 мл ^b
^a Агарын гелийн чанараас хамаарна.	
^b Амфотерицин В уусмал хэрэглэж байгаа бол 925 мл (В.3.5.2-ыг үзэх).	

В.3.1.2 Найрлага

Хуурайшуулсан бэлэн суурь болон тэжээлийн суурийн орц бүрийг буцлаж буй усанд уусгана.

Автоклав (6.1)-т 121 °C температурт 15 минут ариутгана.

Шаардлагатай тохиолдолд ариутгасны дараа, рН-ийг 25 °C температурт $7,2 \pm 0,2$ болгож тохируулна.

В.3.2 Налидиксийн хүчлийн уусмал

Налидиксийн хүчлийн натрийн давс	0,02 г
Натрийн гидроксид (0,05 моль/л)	5 мл

Налидиксийн хүчлийн давсыг 5 мл натрийн гидроксидод уусган 0,45 μм нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.3.3 Цефтазимидийн уусмал

Цефтазимид	0,02 г
Ус	5 мл

Цефтазимидийг 5 мл усанд уусган 0,45 μм нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.3.4 Полимиксин В-ийн уусмал

Полимиксин В сульфат	76 700 IU
Ус	5 мл

Полимиксин В-ийг 5 мл усанд уусгана. 0,45 мкм нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.3.5 Антибиотикийн нэмэлт

В.3.5.1 Циклогексимидийн уусмал

Циклогексимид	0,05 г
Этанол	2,5 мл
Ус	2,5 мл

Циклогексимидийг 2,5 мл этанолд уусгасны дараа нь 2,5 мл ус нэмнэ. 0,45 мкм нүхтэй мембранаар шүүж ариутгана.

В.3.5.2 Амфотерицин В-ийн уусмал (Циклогексимидийн уусмалтай ижил)

Амфотерицин В	0,01 г
HCl (1 моль/л)	2,5 мл
Диметилформамид(DMF)	7,5 мл

